

Усны нөөцийг хамгаалах талаар авах  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Монгол орны усны нөөцийн хомсдол, бохирдлын өнөөгийн байдал, цаашид баримтлах чиглэл”-ийн тухай Монгол Улсын Засгийн газраас ирүүлсэн холбогдох баримт материалтай ажлын журмаар танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

Усны тухай болон холбогдох бусад хуульд ус бохирдуулсны болон хомсдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг тогтоож мөрдүүлэх, ашиглагч нь хамгаалах хариуцлагын тогтолцоог чангатгах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

Балгасын улаан нуур, Бор хөөвөрийн говь, Баян тоорой, Эхийн гол, Шавдал овоо, Зайрмагтай зэрэг газрын доорхи цэнгэг усны томоохон ордууд болон Хангайн нуруун дахь гол мөрний эхийг тусгай хамгаалалтад авах талаархи саналыг ойрын үед боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх.